

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт зарим өөрчлөлтийг оруулах, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх субъектийн эрх, үүрэг, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зарим нэр томъёог хуульд нийцүүлэх замаар хууль хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгахын тулд хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хэлэлцүүлгийн явцад ажлын хэсгийг байгуулан, хөгжлийн бодлого болон загвараа зөв тодорхойлж, хөгжлийн загвартаа баялгийн мөнөжмөнтээ зөв тодорхойлох, худалдааны яам байгуулах, аялал жуучлалыг хөгжүүлэх, дижитал эдийн засаг гэх мэт эдийн засгийн бодлогын шинэ асуудлыг суурьшуулах зэрэг асуудлыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг жилийн төлөвлөгөөг урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж, Улсын Их Хурлаар хөгжлийн төлөвлөгөөг батлах хугацааг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулж, адил хугацаанд баталдаг болох, Хөгжлийн яам байгуулах асуудлыг хамтад нь шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хувийн хэвшлээ дэмжиж, улсын хөгжлийг тодорхойлоход оролцдог байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төр зөвхөн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг тогтолцоонд шилжих, Хөгжлийн яамыг ойрын хугацаанд байгуулж, урт удаан хугацаанд тогтвортой ажиллуулах, энэ чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарах шаардлагатай гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биөийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хэмжил зүйн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР